



МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.6, 46.10 дугаар зүйл, Мандал Даатгал ХК-ийн Дүрмийн 8.14 дүгээр зүйл болон компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 01 сарын 30-ны өдрийн хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Мандал Даатгал” ХК нь 2025 онд 13.1 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2025 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 14.74 төгрөг буюу нийт 8,742,095,304.08 (найман тэрбум долоон зуун дөчин хоёр сая ерэн таван мянга гурван зуун дөрөв) төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашгийг 2026 оны 03 сарын 31-ний өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлж олгохыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшинд даалгасугай.
4. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
5. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн энэхүү шийдвэрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ